

“ХАМГААЛАГЧИЙН АЖЛЫН ХУВЦАС НИЙЛҮҮЛЭХ”

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: *Хамгаалагчийн ажлын хувцас нийлүүлэх*

**Харьцуулалт/
гэрээний дугаар:** *ТБ/202001178*

Төсөв: *46,080,000 төгрөг*

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Төрийн банк нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *Хамгаалагчийн ажлын хувцас нийлүүлэх* тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2020 оны 3-р сарын 05-ны өдрийн 10 цаг 00* минутаас өмнө *Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д цахим хэлбэрээр* ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *тухайн өдрийн 10 цаг 10 минутад* нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг *Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)* -ээс авна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерг оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерг оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерг оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|----------------------------|--|
| ТӨӨЗ 1.1 | <p>Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал баталгаажуулж ирүүлнэ /маягтын дагуу/. 2. Бараа нийлүүлэх хуваарь баталгаажуулж ирүүлнэ /маягтын дагуу/. 3. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас хийсэн хуулбарыг ирүүлнэ. 4. Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолтыг ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Тодорхойлолтын доод хэсэгт байрлах баркод болон тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаар гаргацтай байх шаардлагатай. 5. Тендер нээхээс өмнө санал болгож буй барааны загвар бүрээс 1 ширхгийг авч ирж хүлээлгэн өгсөн байна. 6. Байгууллагын тухай танилцуулга ирүүлнэ. 7. Нийлүүлэх барааны брэнд нь MNS эсхүл ISO сертификаттай байх ба эх хувиас хийсэн хуулбарыг ирүүлнэ. 8. Нийлүүлэх барааны дэлгэрэнгүй танилцуулга ирүүлнэ /Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр үзүүлэлтүүдийг харьцуулсан хүснэгт гаргаж баталгаажуулан ирүүлнэ. Аль нэг зүйл заалтыг орхигдуулаагүй байх ба тоон үзүүлэлтүүдийг дурдахгүйгээр зөвхөн “Болно”, “Тийм”, “Хангасан”, “Нийцнэ” гэх зэрэг үгсээр хүснэгтийг бөглөсөн тохиолдолд харьцуулсан хүснэгт ирүүлсэнд тооцохгүй/. 9. Чанарын баталгаат хугацаа 2 жил түүнээс дээш байна /Баталсан албан бичиг ирүүлнэ/. 10. Баталгаат хугацаанд гарсан доголдлыг өөрийн зардлаар шуурхай засварлах, арилгахыг зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 11. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. 12. Харилцагч банк болгоноос хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тодорхойлолт авч ирүүлнэ. 13. Төрийн банкны зүгээс тухайн тендерт оролцогчийн талаар харилцагч банк, харьяа татвар, шүүх, нийгмийн даатгалын хэлтэс болон бусад байгууллагад хандаж лавлагаа, тодруулга хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 14. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд санал болгож буй барааг гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлнэ. |

| | |
|-----------------|--|
| | <p>15. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлнэ.</p> <p>16. Өөрийн нэрийн дэлгүүртэй байх ба түүнийг батлах албан бичиг болон дэлгүүрийн зургыг үл хөдлөхийн гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээний хамт ирүүлнэ.</p> <p>17. 2018, 2019 онуудад Хүчний байгууллагад санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй хувцас гэрээгээр нийлүүлж байсан туршлагын мэдээллийг дэлгэрэнгүй ирүүлнэ. Гэрээ болон акт ирүүлнэ. Эсхүл гэрээ болон гэрээний үүргээ биелүүлсэн тухай захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>18. 2019 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн тайлан ирүүлнэ /Сангийн яамны И-Баланс цахим системд шивэгдэж баталгаажсан байх/.</p> <p>19. Ашигтай ажилласан байх жилийн тоо: 2019 он.</p> <p>20. Борлуулалтын орлогын хэмжээ: 2019 оны борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Хувилбарт үнийн санал ирүүлэхгүй. • Тендерийн баримт бичгийг ТООЗ 1.1-д заасан дарааллын дагуу эмхтгэж, дугаарлаж ирүүлнэ. • ТШӨХ-т заасан баримт бичгүүдээс аль нэгийг ирүүлээгүй, шаардлага хангаагүй, тендерийн маягтын үг өгүүлбэрийг өөрчилсөн эсхүл орхигдуулсан бол тендерээс татгалзах үндэслэл болно. Мөн ирүүлсэн баримт бичиг уншигдахгүй, гаргацгүй тохиолдолд ирүүлээгүйд тооцно. • Харилцагч банк, татвар, шүүхийн байгууллагын тодорхойлолтуудыг тендер зарласнаас хойших хугацаанд авсан байх ба эх хувиас хийсэн хуулбарыг ирүүлнэ. • Тендерийн хэл нь Монгол хэл дээр байна. Гадаад хэл дээрх бүх материалыг Монгол хэлрүү баталгаат орчуулгын товчоогоор орчуулан ирүүлнэ. • Гадаадын этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй. |
| <p>ТООЗ 2.1</p> | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><i>2020 оны 3-р сарын 05-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д цахим хэлбэрээр хүлээн авна.</i></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн тоологдох, цахим систем ашиглан илгээх нэг болон нийт файлын хэмжээ нь хязгаарлагдмал байдаг зэргийг анхаарна уу. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> |
| <p>ТООЗ 2.1</p> | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв</i></p> |

| | |
|----------|--|
| | <p>2-р байр, 2-р давхар, 202 тоот өрөө. Утас: 11-310103 /Дотуур дугаар: 4155, 4503, 4310/</p> <p>Огноо: 2020 оны 3-р сарын 05-ны өдөр.</p> <p>Цаг: 10 цаг 10 минут</p> |
| ТӨӨЗ 2.3 | <p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичиг. <p>Тендерт оролцогч нь тендерийн материалд дээр заасан баримт бичиг, материалуудаас “Хувь хүний нууцын тухай” хууль болон “Байгууллагын нууцын тухай” хуулиар ил болгохыг хориглосон мэдээллийг ялгаж ирүүлэх ба тэдгээрийг хуулийн дагуу ил болгохыг хориглосон зайлшгүй үндэслэлийг бичгээр тайлбарласан байна.</p> |
| ТӨӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p> |

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг хангасан байна.

1.1 ХАМГААЛАГЧИЙН ХАГАС ТҮРИЙТЭЙ ГУТАЛ

МАТЕРИАЛ: Хромон арьс
1200 D Нейлон
Ус нэвтрэхгүй, бактер эсэргүйцдэг, чийг гадагшлуулдаг,
биед эвтэйхэн e-Vent® доторлогоо

ХЭРЭГЛЭЭ: Сүлжмэл, нейлонон үдээстэй
Улавч нь зөөлөн, биед эвтэйхэн
Өсгийгөөс өлмий хүртэл 8 мм уналттай
Гутлын ул нь хальтрахгүй, улны нум нь олс болон шатаар авирч
буухад зориулагдсан
Хурдан тайлж, өмсөх зориулалттай төмөр бус ҮКК
цахилгаантай
Нейлон түрий нь уян бөгөөд тогтвортой

ӨНГӨ: Хар

ТОО ШИРХЭГ 18

1.2 ХАМГААЛАГЧИЙН ДОТОР ЦАМЦ

МАТЕРИАЛ: Ханцуй, зах, тохойны давхар нөхөөс, халааснууд: 65% Полистер, 35% Хөвөн, 174гр TDU® Ripstop цууралт зогсоогч, Teflon® бүрхүүл
Цээж, нуруу хэсэг: 55% Хөвөн, 37% Полистер, 8% Спандекс буюу сунадаг материал
Хажуу болон хүзүү хэсэг: 55% Хөвөн, 41% Полистер, 4% Спандекс тор

ХЭРЭГЛЭЭ Чийг гадагшлуулдаг, тохойны давхар нөхөөстэй, ханцуй дээрээ ташуу халаастай, таних тэмдэг, эмблем наах зангуутай

ӨНГӨ: Ногоон

ТОО ШИРХЭГ 18

1.3 ХАМГААЛАГЧИЙН ДОТОРТОЙ КУРТКА

МАТЕРИАЛ: Гадар: 100% Нилон, Гадар хүрэмний дотор: 100% Нилон
Салдаг ноосон дотор цамц: 100% Полистер, салхи нэвтрэхгүй цамц,
мөрний хэсгийн оруулга: 100% Нилон

ХЭРЭГЛЭЭ: Гадар хүрэм нь салхи, ус нэвтрэхгүй, амьсгалдаг, бат бөх
Юүдэн нь ус нэвтрэхгүй, захны хэсэг руу хурааж болдог
Арын доод хэсэгт халаастай.
Энгэр болон ардаа таних тэмдэг тогтоогчтой: Хэмжээ: энгэр 12.7см х

14см, ардаа 31.75см х 22.86см
Ханцуй дээрээ цахилгаантай халаастай
Салдаг дотор ноосон цамц нь салхи нэвтрэхгүй, дангаар нь өмсөж болно
Гадар хүрэм болон дотор ноосон цамц нь бичиг баримтны нууц халаастай
Цахилгаантай урд халаас нь ноосон дотортой
Хажуугийн цахилгаан нь агаар оруулах ба гар буу гаргахад хялбар.
Удаан эдэлгээтэй

ӨНГӨ: Хар

ТОО ШИРХЭГ 18

1.4 ХАМГААЛАГЧИЙН ӨМД

МАТЕРИАЛ: 65% Полистер 35% Хөвөн
174гр Цуурахгүй, Teflon® бүрхүүлтэй

ХЭРЭГЛЭЭ Бат бөх, биед эвтэйхэн
Teflon® бүрхүүл нь шороо тоос, уснаас хамгаална
Ташаандаа резинэн сойлттой
Өргөн, гүн, давхар оёдлоор бэхжүүлсэн халаастай
Ачаалал ихтэй хэсэгтээ 3 давхар оёдолтой
Хажуугийн 2, ташаандаа 2, ар талдаа 2 халаастай
Халааснууд нь тагтай
Өвдөг хэсэгтээ давхар нөхөөстэй, дотор талаасаа өвдөгний хамгаалалт хийх халаастай
Суудлын хэсэгтээ давхар нөхөөстэй
Өмдний доод хэсэгт далд шнуртэй

ТОВЧИЛГОО: Урдаа YKK цахилгаантай
Металл PRYM^R кнопон товчтой
Арын болон хажуугийн халаасны товч нь 4 нүхтэй Меламин товч нь хайлахгүй, шатахгүй, хагарахгүй
Хажуугийн болон арын халааснууд тагтай

ӨНГӨ: Ногоон

ТОО ШИРХЭГ 18

1.5 ХАМГААЛАГЧИЙН ГИТЛ

МАТЕРИАЛ: 65% Полистер 35% Хөвөн
174гр Цуурахгүй, Teflon® бүрхүүлтэй

ХЭРЭГЛЭЭ: Бат бөх, биед эвтэйхэн
Teflon® бүрхүүл нь шороо тоос, уснаас хамгаална
Ачаалал ихтэй хэсэгтээ 3 давхар оёдолтой
Энгэрийн 2 халаас нь гүн, үзэгний оруулгатай
патенттай бичиг баримтны нууц халаастай
Энгэрийн товч нь даруулгатай

Мөрдөс, эмблем тогтоогч дагалдана
Тохой хэсэгтээ давхар нөхөөстэй, дотор талаасаа тохойны
хамгаалалт хийх халаастай
Зүүн хацуйны доод хэсэгт үзэгний хос халаастай
Товч – 4 нүхтэй Меламин товч нь хайлахгүй, шатахгүй, хагарахгүй
30 Ligne товч: Хоолой хэсэгт-1, энгэрий 4 далд товч, бугуй тус бүр-
2, ханцуй тус бүрийн даруулга-1, запас-1, мөрдөсний-2
Халааснууд тагтай

ӨНГӨ: Ногоон

ТОО ШИРХЭГ 18

1.6 ХАМГААЛАГЧИЙН ХАГАС ТҮРИЙТЭЙ ГУТАЛ /ӨВӨЛ/ МАТЕРИАЛ:

Усны хамгаалалттай хромон арьс, Kevlar өсгийн хамгаалалт, чийг
гадагшлуулдаг, биед эвтэйхэн e-Vent ® доторлогоо,

ХЭРЭГЛЭЭ: Сүлжмэл, нейлонон үдээстэй
Улавч нь Ortholite imperial хөлд ирэх ачаалал
багасгадаг улавчтай,
Түрий нэмэлт оёдол хамгаалалттай, биеийн
тэнцвэр алдагдуулахгүй.

Гутлын ул нь Vibram, megalip ус тос халтирхаас хамгаалах мөн
доргилтын хүчийг багасгадаг

ӨНГӨ: Хар

ТОО ШИРХЭГ 18

2. Стандарт:

Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр
стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.

3. Баглаа, боодол:

Бараа нь хайрцаг сав, баглаа боодолтой, шинэ байна. Баглаа боодол бүрийн гадна талд
бүтээгдэхүүний нэр, тоо ширхгийг тэмдэглэсэн товъёог наасан байна.

4. Бараа хүргэх газар:

Барааг захиалагчийн товлосон газар хүргэж, угсарч, төрийн банкны бараа, ажил үйлчилгээ
хүлээлцэх актаар хүлээлгэн өгч гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулна. /Улаанбаатар
хотод хуваарьтай барааг хүргэж, угсарч хүлээлгэн өгнө. Орон нутагт хуваарьтай барааг ачаа
тээврийн газар хүргэж ачилцаж өгнө./

5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| № | Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|---|---|--------------------------------------|------------|-------------|--|---|--------------------------|--------------------------------------|
| | | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | ХАМГААЛАГЧИЙН ХАГАС ТҮРИЙТЭЙ ГУТАЛ | Техникийн тодорхойлолт 1-т зааснаар. | 18 | Ширхэг | Техникийн тодорхойлолт 4-т зааснаар. | 1 | 45 | |
| 2 | ХАМГААЛАГЧИЙН ДОТОР ЦАМЦ | Техникийн тодорхойлолт 1-т зааснаар. | 18 | Ширхэг | Техникийн тодорхойлолт 4-т зааснаар. | 1 | 45 | |
| 3 | ХАМГААЛАГЧИЙН ДОТОРТОЙ КУРТКА | Техникийн тодорхойлолт 1-т зааснаар. | 18 | Ширхэг | Техникийн тодорхойлолт 4-т зааснаар. | 1 | 45 | |
| 4 | ХАМГААЛАГЧИЙН ӨМД | Техникийн тодорхойлолт 1-т зааснаар. | 18 | Ширхэг | Техникийн тодорхойлолт 4-т зааснаар. | 1 | 45 | |
| 5 | ХАМГААЛАГЧИЙН ГИТЛ | Техникийн тодорхойлолт 1-т зааснаар. | 18 | Ширхэг | Техникийн тодорхойлолт 4-т зааснаар. | 1 | 45 | |
| 6 | ХАМГААЛАГЧИЙН ХАГАС ТҮРИЙТЭЙ ГУТАЛ /ӨВӨЛ/ | Техникийн тодорхойлолт 1-т зааснаар. | 18 | Ширхэг | Техникийн тодорхойлолт 4-т зааснаар. | 1 | 45 | |

Жич:

1. Нийлүүлж буй барааг хүргэж өгөх, ачиж буулгах, тээвэрлэх ажлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.
2. Барааг авахын өмнө туршилтын журмаар загвартай танилцана.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [mo] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан mo] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээ байгуулсны дараа гэрээний үнийн дүнгийн 40 хувийг, барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 60 хувийг тус тус төлнө.
- OR
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9) 9.1. Алданги оногдуулах хувь: 0.5
- Алдангийн нийт дүн: 10

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]